

**10-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ  
А ХУВИЛБАР**

Хугацаа: 60 минут  
40 оноо

Нийт

Анги:                    нэр:

**Савын гурван гэм**

Нэгэн талаас багш нь номлох, нөгөө талаас шавь нь ихэд хичээнгүйлэн сайн үйлийн барилдага тэгш бүрдвээс сая эрдмийн хишиг хүнд тогтох жамтай. Энэ нь цэвэр ариун, бүрэн бүтэн саванд өрөм загсдагтай адил.

Нэгэн зүйл. Номын ширээнд багшийн урд суувч чихээр үл сонсон өөр юм бодох нь хөмөрсөн тогоонд сүү дүүргэж болдоггүйтэй үлгэр нэг.

Хоёр зүйл. Багшийн айлдах номыг чихээр сонсовч хагас хугас тогтоох нь цоорхой тогоон дахь сүү мөдхөн гоожин дусах мэт.

Гурван зүйл. Чихээр сонсовч утгыг үл ухаарах, ухаарлаа ч буруу тогтоох нь бохир саванд хийсэн сүү гашлан ээдэж, өрөм цөцгий суудаггүй лүгээ нэгэн адил.

Нэгтгэн дүгнэвээс, уруу харуулсан сав, цоорхой сав, бузартай сав ийм гурван зүйл саванд сүү хөөрүүлж загсааж болдоггүй. Үүн лүгээ адил багшийн номыг

Сонсдоггүй

Алдаг оног сонсдог

Сонслоо ч утгыг буруу ухаардаг шавь эрдэм сурдаггүй.

“Хамгийн сайн боловсрол гэдэг хүн өөрөө өөртөө хүртээдэг боловсролыг хэлдэг”

В. Скотт хэлжээ. Хүн хийсэн хичээлийнхээ хэмжээ, уншсан номын тоогоор цэцэн болдоггүй. Хичээллэх арга, өөрийн чинь мөрдөх зорилгод тохирч байна уу, үгүй юү, нэгэн үзүүрт сэтгэлээр хичээлдээ шамдаж байна уу, хичээл зүтгэл чинь хэвшил заншил болж байна уу гэдэг л гол асуудал. Шургуу чанга хичээж зүтгэсээр байвал хэн ч гэсэн хүний урд гишгэж чадна гэж хөдөлмөрч хүмүүс ярьж байдаг. Энэ үнэн л дээ.

**Ажиллах даалгавар:**

**Даалгавар-1 Дээрх эхэд дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг тодорхойлоорой. /2 оноо/**

- А. Гурван савны тухай                    Б. Багш шавь хоёрын тухай  
В. Хичээнгүйлэн суралцаж байж сая эрдэм сурах тухай

**Эхийн гол санааг илэрхийлсэн хөтөч өгүүлбэрийг олоорой. /2 оноо/**

- А. Нэгэн талаас багш нь номлох, нөгөө талаас шавь нь ... эрдмийн хишиг хүнд тогтох жамтай.  
Б. Шавь эрдэмд суралцах нь цэвэр ариун, бүрэн бүтэн саванд өрөм загсдагтай адил.  
В. Хамгийн сайн боловсрол гэдэг хүн өөрөө өөртөө хүртээдэг боловсролыг хэлдэг.  
Г. Шургуу чанга хичээж зүтгэсээр байвал хэн ч гэсэн хүний урд гишгэж чадна

**Даалгавар-2 Эхийн гол санааг хэлцээр илэрхийлэн бичээрэй. /4 оноо/**

**Даалгавар-3 Зохиогчийн үзэл бодлоо дэмжсэн баримтыг ялган бичээрэй. /4 оноо/**

**Даалгавар-4 Эхээс зөв бичгийн дүрмээр бичсэн үгсийн жишээ нэгийг олж бичнэ үү. /1 оноо/**

Зөв бичгийн дүрэм	Эхээс тохирох жишээ	Зөв бичгийн дүрмийн тайлбар
Балархай эгшгийг гэж бичсэн		

**Даалгавар-5**

**“олдвор+ыг=?” гэсэн үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарла. /2 оноо/**

**Даалгавар-6 /5 оноо/**

. Өгүүлбэрүүдийг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулаарай.

- |   |   |   |           |
|---|---|---|-----------|
| a | Олон дайнд оролцон чадал хүчиндээ эрдэж явснаа санахад чиний илдийн дор явж би хэзээ ч чадахгүй.  | 1 | Адилтгал  |
| b | Үндэс мөчир бөхтэй Хорхоногийн саглагар мод шиг цэцэглэн ганхаж явсан юм сан.   | 2 | Амьдчилал |
| c | Тэр газрын цээжийг аниртан чагнаваас монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ.  | 3 | Хэтрүүлэл |
| d | Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр дув дуугүй урсах дор   | 4 | Төлөөлөл  |
| e | Ялгуун саарал морин нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөр ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжихүй нь агаар дор дэгдэж, үүлэн дор умбан алдана. Д.Нацагдорж "Хөдөө талын үзэсгэлэн" |   |           |

**Даалгавар-7 /10 оноо/**

**Эхийн гол санааг 60-70 үгэнд багтаан бичээрэй.**

**Даалгавар-8 /2 оноо/**

МНТ-ны "Өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгох" гэсэн хэсэгт уран дүрслэлийн ямар арга байна вэ?

- A. егөөдөл    B. ихэсгэл    C. төлөөлөл    D. багасгал

**Даалгавар-9 /2 оноо/**

Монголын нууц товчоо зохиол нь **"уран зохиолын дурсгал"** болохыг аль хэсгээр баталж болох вэ?

- A. Ширмэн төмөр магнайтай, Шивээ хурц хэлтэй, Ган төмөр зүрхтэй, Гадас цүүцэн хошуутай, Галзуу дөрвөн нохой
- B. Хаан эзэндээ халдсан харц ардыг ураг төрлий нь хүртэл устга" гэж зарлиг болов. Тэгээд Жамухын нүдний өмнө түүнд халдсан ардыг алав.
- C. Барс жил (1206) Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өргөв.
- D. "Улс төрийг байгуулалцсан урьдын гавьяат нөхдөө угсаатан ноёд болгож, мятралгүй зүтгэсэн миний хайрт нөхдийг мянганы ноёд өргөмжлөв.

**Даалгавар-10**

**Дараах өгүүлбэрийг үндэсний бичгээр бичээрэй. /5 оноо/**

Бурам-ийар тэдхүхү-бэр, урм-а-бар тэдхү. Намур-ун шир-а нара чим-а дэгэр-э тусун-а. Өндөр уулын оргилд мацан гарвал өөр нэг уулыг олж хардаг.

Монголын нууц товчоо зохиол нь **"уран зохиолын дурсгал"** болохыг аль хэсгээр баталж болох вэ?

- A. Ширмэн төмөр магнайтай, Шивээ хурц хэлтэй, Ган төмөр зүрхтэй, Гадас цүүцэн хошуутай, Галзуу дөрвөн нохой
- B. Хаан эзэндээ халдсан харц ардыг ураг төрлий нь хүртэл устга" гэж зарлиг болов. Тэгээд Жамухын нүдний өмнө түүнд халдсан ардыг алав.
- C. Барс жил (1206) Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өргөв.
- D. "Улс төрийг байгуулалцсан урьдын гавьяат нөхдөө угсаатан ноёд болгож, мятралгүй зүтгэсэн миний хайрт нөхдийг мянганы ноёд өргөмжлөв.

**10-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ  
Б ХУВИЛБАР**

Анги:                    нэр:

Хугацаа: 60 минут  
40 оноо

Нийт

Зопа Ринбүчи

**Хүний зан араншин**

Хүний зан аашийг ойлгох маш хэцүү. Орох газар нь үл мэдэгдэх битүү ширэнгэтэй адил. Хүний зангаас араатны занг ойлгох нь хялбар. Зангаар нь хүнийг дөрвөн зэрэгт хуваана.

1-р зэрэг: Зовлон эдлэгч хүмүүс. Буруу сургаалын уршгаар биеийн зовлонд учирсан хүмүүс.

2-р зэрэг: Бусдад зовлон учруулагч хүмүүс. Амьтан алдаг, хулгай хийдэг, мөн бусад тэнэг үйлдлүүдийг хийдэг хүмүүс.

3-р зэрэг: Өөрсдийгөө зовоож, бусдад зовлон тарьдаг.

4-р зэрэг: Өөрсдөө зовдоггүй, бусдад зовлон тарьдаггүй хүмүүс.

Түүнээс гадна энэ ертөнцөд 3 янзын хүмүүс байна. Чулуун дээр сийлсэн бичиг шиг хүн, элсэн дээр бичсэн бичигтэй адил хүн, усан дээр бичсэн бичигтэй адил хүн байна. Чулуун дээр сийлсэн бичигтэй адил хүн бол дандаа уурладаг, уур нь гардаггүй, чулуун дээр сийлсэн мэт арилахгүй. Элсэн дээрх бичигтэй адил хүмүүс бол голдуу уурладаг, гэвч уур нь түргэн гарна. Усан дээрх бичигтэй адил хүмүүс бол бусдад муу үг хэлдэггүй, тэнэг мулгуу үг сонслоо ч хайхардаггүй, сэтгэл нь дөлгөөн тайван байдаг.

1-р хэлбэр нь. Зан араншингаар ердийн хүмүүс, түргэн зантай хөнгөндүү, тогтвор муутай.

2-р хэлбэр нь. Занг нь ойлгоход бэрх, даруу томоотой, маш болгоомжтой, өөрийн хүслийг хянаж чаддаг.

3-р хэлбэр нь. Занг нь ойлгоход тун хэцүү буюу ойлгомжгүй. Өөрөөсөө энэ ертөнцийн шунал бүхнийг зайлуулж чадсан.

Ийнхүү ертөнц дээр маш олон янзын хүмүүс байна. Тус бүрийнх нь занг ойлгоно гэдэг бэрх.

**Даалгавар-1 Дээрх эхэд бүхэлдээ дэвшүүлсэн асуудал буюу сэдвийг тодорхойлоорой. /2 оноо/**

А. Ертөнцөд гурван янзын хүн байдаг тухай

Б. Ертөнцөд олон янзын зан ааштай хүн байдаг тухай

В. Хүн зан ааш араатны зан ааштай адилхан тухай

**Эхийн гол санааг илэрхийлсэн хөтөч өгүүлбэрийг олоорой. /2 оноо/**

А. Хүний зан аашийг ойлгох маш хэцүү.

Б. Чулуун дээр сийлсэн бичиг шиг хүн... усан дээр бичсэн бичигтэй адил хүн байна.

В. Хүний зангаас араатны занг ойлгох нь хялбар.

Г. Ийнхүү ертөнц дээр маш олон янзын хүмүүс байна.

Зохиогчийн үзэл бодлоо дэмжсэн баримтыг ялган бичээрэй. /2 оноо

**Даалгавар-2 Эхийн гол санааг хэлцээр илэрхийлэн бичээрэй. /2 оноо/**

**Даалгавар-3 зохиогчийн үзэл бодлоо дэмжсэн баримтыг ялган бичээрэй. /4 оноо/**

**Даалгавар-4 Эхээс зөв бичих дүрмээр бичсэн үгсийн жишээ нэгийг олж бичнэ үү. /1 оноо/**

Зөв бичгийн дүрэм	Эхээс тохирох жишээ	Зөв бичгийн дүрмийн тайлбар
Балархай эгшгийг гэж бичсэн		

**Даалгавар-5 “нөхцөл+өөр=?” гэсэн үгийн зөв бичгийн дүрмийг тайлбарла. (2 оноо)**

**Даалгавар-6 /5 оноо/**

. Өгүүлбэрүүдийг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулаарай.

- |   |   |   |           |
|---|---|---|-----------|
| a | Олон дайнд оролцон чадал хүчиндээ эрдэж явснаа санахад чиний илдийн дор явж би хэзээ ч чадахгүй.  | 1 | Адилтгал  |
| b | Үндэс мөчир бөхтэй Хорхоногийн саглагар мод шиг цэцэглэн ганхаж явсан юм сан.   | 2 | Амьдчилал |
| c | Тэр газрын цээжийг аниртан чагнаваас монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ.  | 3 | Хэтрүүлэл |
| d | Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр дув дуугүй урсах дор   | 4 | Төлөөлөл  |
| e | Ялгуун саарал морин нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөр ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжихүй нь агаар дор дэгдэж, үүлэн дор умбан алдана. Д.Нацагдорж "Хөдөө талын үзэсгэлэн" |   |           |

**Даалгавар-7 /10 оноо/**

**Эхийн гол санааг 60-70 үгэнд багтаан бичээрэй.**

**Даалгавар-8 /2 оноо/**

МНТ-ны "Өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгох" гэсэн хэсэгт уран дүрслэлийн ямар арга байна вэ?

- A. егөөдөл    B. ихэсгэл    C. төлөөлөл    D. багасгал

**Даалгавар-9 /2 оноо/**

Монголын нууц товчоо зохиол нь "уран зохиолын дурсгал" болохыг аль хэсгээр баталж болох вэ?

- A. Ширмэн төмөр магнайтай, Шивээ хурц хэлтэй, Ган төмөр зүрхтэй, Гадас цүүцэн хошуутай, Галзуу дөрвөн нохой
- B. Хаан эзэндээ халдсан харц ардыг ураг төрлий нь хүртэл устга" гэж зарлиг болов. Тэгээд Жамухын нүдний өмнө түүнд халдсан ардыг алав.
- C. Барс жил (1206) Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өргөв.
- D. "Улс төрийг байгуулалцсан урьдын гавьяат нөхдөө угсаатан ноёд болгож, мятралгүй зүтгэсэн миний хайрт нөхдийг мянганы ноёд өргөмжлөв.

**Даалгавар-10 Дараах өгүүлбэрийг үндэсний бичгээр бичээрэй. /5 оноо/**

Хүмүн нэр-э-бэн, тогус бдү-бэн

Үхэр шар мөргүлдүн малчин хүмүн-и зугацагулун-а.

Өндөр уулын оргилыг нэгэн удаа давбал өөр нэг зам тодорхой.